

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй.

1/ 2.2 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

“10.Шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй болсон бол тухайн хэргийг өөр аймаг дахь сум буюу сум дундын, эсхүл дүүргийн шүүхэд Улсын дээд шүүхийн эрүүгийн танхимын Тэргүүн шүүгчийн захирамжаар, нэг аймаг дахь өөр сум буюу сум дундын, түүнчлэн өөр дүүргийн шүүхэд тухайн аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шүүхийн харьяалал тогтоон шилжүүлнэ.”

2/4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.24 дэх заалт:

“2.24.Прокурорын даалгаварт гаргасан мөрдөгчийн саналыг дээд шатны прокурор 3 хоногийн дотор шийдвэрлэнэ.”

3/6.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“8.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2.14 дэх заалт нь энэ хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1-4 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах байгууллага хооронд өгөх даалгаварт хамаарахгүй.”

4/8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.13, 1.14 дэх заалт:

”1.13.өөрт хамааралтай шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлттэй танилцах;”

“1.14.өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;”

5/14.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“8.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу барьцааны мөнгийг байршуулах журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Сангийн сайд хамтран батална.

6/16.8 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг:

“6.Хавтаст хэрэгт тусгагдсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн болох баримт, мэдээллийн талаархи мөрдөгчийн нууц ажиллагааны магадлагаатай Төрийн

болон албаны нууцын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасан албан тушаалтан танилцана.

7.Хавтаст хэрэгт авагдсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг мөрдөн байцаалтын шатанд тухайн хэргийг мөрдөн шалгах байгууллагын саналыг үндэслэн прокурорын зөвшөөрлөөр бүрэн болон хэсэгчлэн нууцын зэрэглэлд оруулж болно.”

7/29.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:

“9.Нэг үйлдэлд хэд хэдэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн бол хэргийг нэгтгэж хэрэг бүртгэлт явуулна.”

8/30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6 дахь заалт:

“1.6.шинжээч томилох.”

9/30.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно.”

10/30.10 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

“4.Мөрдөгчийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурор хянаж, 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.”

5.Прокурор хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах мөрдөгчийн саналыг үндэслэлгүй гэж үзвэл гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг дахин шалгуулахаар буцаах, эсхүл хэрэг бүртгэлтийн хэрэг нээх шийдвэр гаргаж болно.”

11/32.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“9.Яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчилсөн тохиолдолд энэ хуулийн 7.3, 7.4-т заасныг баримтлан яллагдагчаас дахин мэдүүлэг авна.”

12/32.10 дугаар зүйлийн 7,8 дахь хэсэг:

”7.Яллагдагч яллах дүгнэлтийг гардаж авахаас татгалзвал энэ талаар тэмдэглэл үйлдэж, шаардлагатай бол дуу дурсний бичлэгээр баримтжуулан хэргийг шүүхэд шилжүүлнэ.

8.Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг шүүхэд шилжүүлнэ.”

13/34.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Өсвөр насны шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 2.11 дэх заалтад “явуулах” гэсний дараа “,эс зөвшөөрвөл даалгаврыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор дээд шатны прокурорт бичгээр саналаа 1 удаа гаргах;” гэж, 12.4 дүгээр зүйлийн 1.6 дахь заалтын “эд зүйл” гэсний дараа “мал амьтан,” гэж, 15.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорт” гэсний дараа “шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “”Улсын ерөнхий прокурорын газарт” гэснийг “дээд шатны прокурорт” гэж, 15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шийдвэрлэнэ” гэсний дараа “Энэхүү шийдвэр эцсийн байна.” гэж, 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хуулийн” гэсний дараа “5.5,” гэж, 17.3 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “5.5,” гэж, 17.4 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “даруй” гэсний дараа “,эсхүл 7 хоногийн дотор” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “хуулийн” гэсний дараа “5.5,” гэж, “хүрээнд” гэсний дараа “шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр” гэж, 26.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг алах” гэсний дараа “12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг/Хүчиндэх/ гэж, 30.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “гомдол” гэсний дараа “,мэдээлэл” гэж, 30.8 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “саналыг” гэсний дараа “72 цагийн дотор” гэж, 30.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “саналыг” гэсний дараа “хэргийн хамт 3 хоногийн дотор” гэж, 32.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хамт” гэсний дараа “3 хоногийн дотор” гэж, 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “прокурор” гэсний дараа “яллагдагч, түүний өмгөөлөгч” гэж, мөн хэсгийн “бичих” гэсний дараа “гомдол гаргах” гэж, 40.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шүүгч” гэсний дараа “тухайн хэргийг илтгэж,” гэж, 40.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “болгох” гэсний дараа “,өөрчлөх” гэж, 45.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “таслан” гэсний өмнө “тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, цагдан хорих” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.14 дэх заалт:

“2.14.Өөр орон нутагт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах шаардлага гарвал энэ тухай даалгаврыг бичгээр гаргах ба түүнийг хүлээн авсан мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах байгууллага заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар хүргүүлэх;”

2/8.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хуульд, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

3/9.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хуульд, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

4/10.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Энэ хуулийн 13.5 дугаар зүйлд заасны дагуу хамтран ажиллах этгээдээр тогтоосон шийдвэр гаргасан шүүгч уг шийдвэр нь хүчингүй болсон тохиолдолд

хамтран ажиллах этгээдээр тогтоож байсан хүний үйлдсэн тухайн гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд оролцохгүй.”

5/16.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Хавтаст хэрэгт тусгагдаагүй баримт сэлт, мэдээллийг шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд танилцуулахыг хориглоно.”

6/30.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэргийг дуусгаж, хэргийн хамт дараахь саналыг 3 хоногийн дотор прокурорт хүргүүлнэ.”

7/34.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Шүүх нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж болно.”

8/37.5 дугаар зүйл:

“37.5 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

1.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно.Энэ хугацаанд ялтан д шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.

2.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

4.Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

5.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

6.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан өсвөр насны болон бусад хүн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.”

9/39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж болно.”

10/39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-1.3 дахь заалт:

“1.1.анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгох;

1.2.анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;

1.3.анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгох;”

11/40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дараахь үндэслэлээр оролцогч хяналтын журмаар гомдол, прокурор, дээд шатны прокурор эсэргүүцэл гаргаж болно:

1.1.шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;

1.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, эсхүл нөлөөлж болохуйц нөхцөл байдал тогтоогдсон.”

12/40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-1.4 дэх заалт:

“1.1.анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хүчингүй болгох;

1.2.анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;

1.3.анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох;

1.4.анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгон хэргийг хэрэгсэхгүй болгох буюу цагаатгах;”

4 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “адил шатны өөр шүүхийн дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн шийдвэрээр зохих шатны өөр шүүхийн шүүгчийг томилж” гэснийг “тухайн шүүхийн Ерөнхий шүүгч адил шатны өөр шүүхээс бүрэлдэхүүнд шүүгч оруулах хүсэлтийг Ерөнхий шүүгчид нь тавьсны дагуу адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмыг баримтлан шүүхийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг томилох ба” гэж, 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “2.24” гэснийг “2.25” гэж, 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “1.13” гэснийг “1.15” гэж, 12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “ирүүлж болно” гэснийг “ирүүлнэ” гэж, 14.3 дугаар зүйлийн “2” гэснийг “1” гэж, мөн зүйлийн “3” гэснийг “2” гэж, 15.4 дүгээр зүйлийн гарчгийн “хангах” гэснийг “шийдвэрлэх” гэж, 17.1 дүгээр зүйлийн “хохирогчтой эвлэрсэн” гэснийг “энэ” гэж, 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаархи” гэснийг “ялын төрөл, хэмжээ, ялаас чөлөөлөх, ял оногдуулахгүй тэнсэх болон албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэх тухай” гэж, 17.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.3 дахь заалтын “ялыг” гэснийг “ял, албадлагын арга хэмжээг” гэж, 22.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “24” гэснийг “72” гэж, 30.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гомдлыг” гэснийг “гомдол, мэдээллийг” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “гомдолд” гэснийг “гомдол, мэдээлэлд” гэж, 30.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хэсэгт” гэснийг “хэсгийн 1.1-1.5 дахь заалтад” гэж, 30.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эрүүгийн” гэснийг “хэрэг бүртгэлтийн” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “мэдэгдэнэ” гэснийг “мэдэгдэх ба энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан прокурорын шийдвэрийг гомдол, мэдээлэл гаргагч эс зөвшөөрвөл шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор

дээд шатны прокурорт гомдол гаргаж болно” гэж, 30.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “авч” гэснийг “авснаас хойш ажлын 3 өдрийн дотор” гэж, 31.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “6” гэснийг “24” гэж, 39.4 дүгээр зүйлийн “хэргийн болон” гэснийг “хэргийг илтгэж,” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн тухай баталгааг” гэснийг, 17.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.5 дахь заалтын “нөхөн төлөхөө илэрхийлж, хохирогчтой эвлэрсэн” гэснийг, 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас гадна” гэснийг, 34.16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “хэргийн бодит байдлыг тогтооход нөлөөлөхгүй бол” гэснийг, 37.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих,” гэснийг, мөн зүйлийн 3 дахь хэсэг, 37.12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.4 дүгээр зүйлийн 4.4. дэх заалт, 17.5 дугаар зүйл, 34.19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 37.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2 дахь заалт, 39.9 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 40.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 40.8 дугаар зүйлийн 1.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ